



БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДЛААР ЗӨВЛӨХ, НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ  
“ОЗЕМ ИНВАЙРМЕНТАЛ” ХХК

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ  
“ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**/РД: 6470556/**

**УЛААНБААТАР ХОТ 2024 ОН**

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/2024-2028 ОН/

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

**Гол зорилтууд:** Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт орших “Мөнгөн нуруу” ХХК-ийн “Дэнж” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

### БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ЗАРДАЛ

№	Арга хэмжээ	2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, арга хэмжээний төлөвлөгөө/хөрс, ус, агаар/	4 100.0	11 450.0	7 000.0	6 225.0	12 225.0
2	Нөхөн сэргээх, хаалтын арга хэмжээний төлөвлөгөө	-	29 784.0	13 784.0	21784.0	43 568.0
3	Тэрбум мод хөтөлбөр	1 650.0	4 650.0	2 150.0	2 350.0	4 950
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	4 580.0	8 180.0	8 880.0	8 680.0	14 080.0
4	Осол эрсэлийн менежментийн төлөвлөгөө	700.0	700.0	700.0	700.0	700.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4600.0	600.0	600.0	600.0	3100.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1706.0	1706.0	1706.0	1706.0	1706.0
	БОМТ-г түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талд тайлагнах төлөвлөгөө	-	-	-	-	-
	<b>2024-2028 оны БОМТ-ийн зардал</b>	<b>17 336.0</b>	<b>57 070.0</b>	34 820.0	42 045.0	<b>80 329.0</b>
	<b>БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал</b>			<b>231 600.0 сая.төг</b>		

### СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг хүснэгтэд бүрэн эхээр тусгав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү БОМТ-г бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

**СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (сая.₮)	Тоо хэмжээ	Нийт зардал (сая.₮)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ</b>								
Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбай	Тогтмол	-	-	Үйл ажиллагааны зардал	2024-2028 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны Төлбөрийн тухай хууль MNS 4585:2016
Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Шаардлагагүй тохиолдолд тээврийн хэрэгслийг унтрааж байх			-	-			
<b>УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ</b>								
Усан орчин бохирдох,	Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	Удаа	Үйл ажиллагааны зардал		2024-2028 он	“Усны тухай хууль”  Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль  MNS 65 61:2015 MNS 49 43:2015 MNS 6734:2018	
Усны нөөц хомсдох	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 м-ээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 м-ээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож, мөрдөн ажиллах	Төслийн талбай						
Усны чанар	Цэгийн орчны газрыг тэгшилж , хур борооны ус, чийг шүүрч, нэвчихээс сэргийлж урсац зайлуулах суваг татах	Бохир ус зайлуулах цооног, түүнээс үүсэх бохирдлыг хязгаарлах	м <sup>2</sup>	Үйл ажиллагааны зардал		1 удаа	БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан тушаал А-230/127 тоот журам “Ус ашиглалт” хэрэглээг тоолууржуулах журам	
	Бохир ус зөөвөрлөх машин чөлөөтэй орж гарах талбайтай байх		Иж бүрэн					
	Цэгийг бетон, төмөр бетон болон бусад ус үл нэвчих материалаар доторлоно		Удаа	Үйл ажиллагааны зардал		Улиралд 1 удаа	БОАЖ-ын сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам	
	Ус ашиглагч нь цэгийн эзэлхүүний 70-80 % дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бгхий ААН-ээр							

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.								
<b>ХӨРС, ГАЗРЫН ГАДАРГАД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ</b>								
Хөрсний бохирдол	Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбай	Удаа	Үйл ажиллагааны зардал		2024-2028	MNS 5850:2019 “хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ  MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх	
	Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол байгуулах, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, хаалт хамгаалалт хийх			400.0	8	3 200.00		2024 он
	Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх			-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан			2024-2028 он
	Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн талбай	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024-2028 он		
	Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах			Удаа	Үйл ажиллагааны зардал			2024-2028 он
	Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах.	Хуулсан шимт хөрс	Удаа		Үйл ажиллагааны зардал			2024-2028 он
	Хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах			Төслийн талбай	Удаа тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024-2028 он
	Нефтийн бүтээгдэхүүн бүхий хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохирдсон хөрсийг тухай бүрд нь цэвэрлэж байх	Үйл ажиллагааны зардал				2024-2028 он		Газрын тухай хууль MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт”
Олон салаа шороон зам үүсэх нөхцөлд хаах арга хэмжээ авах	Хөрсний элэгдэл, эвдрэлийн нөлөөллийн бүс	Удаа	Үйл ажиллагааны зардал			MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд		
<b>БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ</b>								

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ургамал	Шимт хөрсийг ургамалжуулж түүн доторх ургал эрхтний нөөцийг хамгаалах	Төслийн талбай	Удаа	Биологийн нөхөн сэргээлтийн зардалд тооцоогдсон			2024-2028 он	Ургамал хамгааллын тухай хууль
	Биологийн аргаар нөхөн сэргээх талбайд бэлчээрийн идэмжит ургамлыг тарина.	Төслийн талбай	Удаа					Байгалийн ургамлын тухай хууль
	Хаалтын дараа хяналт мониторинг хийж, нөхөн сэргээсэн талбайг орон нутагт хүлээлгэн өгөх	Төслийн талбай						-
Орчны үзэмжийг сайжруулах	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутаг дэвсгэрээс санал болгосон газраас сонголт хийн мод, бут, сөөг, боролзгоно тарих</b>	Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум	ш	22 500	700.0	15 750.0 сая.төг	2025-2027 он	
	Цэцгийн мандал байгуулах	Уурхайн кемп	ш	350.0	4	1 400.00		
	Тарьсан мод бутны арчилга тордолгоо хийх	--*--	ш	500.0	5 жил	2 500.00		
<b>Нийгмийн хариуцлагын хүрээнд</b>	<b>Гараар алт олборлолтоос хаягдсан талбайг ургамалжуулах 5.5 га</b>	--*--	га	33 500.00			2025-2028 он	MNS 5918:2023 Байгаль орчин. Эвдэрсэн гарыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага
Амьтан	Цахилгаан дамжуулах шугамын шувуунд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	Төслийн талбайн цахилгааны шугам	Ширхэг	100.0	4	400.0	2024 он	Амьтны тухай хууль
<b>Эрчим хүч</b>								
Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал			2024 он	
	Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгон хэрэглэх						2024-2028 он	
<b>НИЙТ ДҮН</b>						<b>47 750.00 сая.төг</b>		

### НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал (сая.төг)	Баримтлах стандарт аргачлал
Уулын ажил болон уурхайн бусад үйл ажиллагааны явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд зогсохгүй байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, хамгаалах нөхөн сэргээлтийн ажлуудыг цогц байдлаар хийх юм.	Байгаль орчныг хамгаалах зардал	--*--	30.0	Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт. MNS 5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт MNS 5916:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008
	Техникийн нөхөн сэргээлт	Эвдрэлд өртсөн талбай	61.8	
	Биологийн нөхөн сэргээлт	ХАА бэлчээрийн зориулалтаар нөхөн сэргээх	10.82	
	Уурхайн хаалтын дараах хяналт шинжилгээ	Хяналт шинжилгээ, хянан магадлагаа	7.0	
<b>Нийт нөхөн сэргээлтийн зардал ба хаалтын зардал</b>			<b>108.92 сая.төг</b>	

Уурхайн нөхөн сэргээлт хийхэд 108.92 сая төгрөг шаардлагатай ба жилд 21.8 сая төгрөгийг уурхайн нөхөн сэргээлт хийхэд зориулж хуримтлал үүсгэнэ. Хаалтын үе шатанд хийгдэх ажлуудын гүйцэтгэлийг улс, орон нутгийн хяналтын байгууллагуудад шалгуулж, дүгнэлт гаргуулсны дараа орон нутагт нь хүлээлгэн өгснөөр уурхайг эцсийн байдлаар хаах ажил дууссан гэж үзнэ.

### НҮҮЛГЭН СУУРЬШУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Мөнгөн нуруу” ХХК нь нь Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутаг дахь Дэнж алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн суурьшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах шаардлагагүй гэж үзлээ.

### ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын талбай орчимд одоогоор археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёлын өв олохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

### БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуудыг тогтоох; Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох	Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын хөрс цаг уурын судалгааг хийж суулгахад тохиромжтой мод, бут, сөөгийг тодорхойлох төлөвлөгөө гаргах	Сонгож авсан талбайд	3.0	3.0	2024 онд	БОННУ-ний аргачлал, Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх гарын авлага
2		Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын шаардлагатай хэсэгт техникийн нөхөн сэргээлт хийх	3.3 га	8400.0	8400.0	2024 онд	
3		Биологийн нөхөн сэргээлт хийх, мод бут суулгах	Сонгож авсан талбайд	3500.0	3500.0	2024	
4		Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд мониторинг хийж, усалж арчлах		Үйл ажиллагааны зардлаар		2024 оноос эхлэн	
5	Нийгмийн салбаруудаас зохион байгуулагдаж байгаа ажилд хандив тусламж үзүүлж дэмжин ажиллана	Нийгмийн салбаруудаас зохион байгуулагдаж байгаа ажилд хандив тусламж үзүүлж дэмжин ажиллах	Сумын ЗД-ын Тамгын газартай	Төсвийн тухай хуулийн 25.3-т заасан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн авах тусламж, хандивын хэмжээ тухайн төсөвт		2024-2028	Орон нутагт хийх бүтээн байгуулалтын ажлын өртөг болон мөнгөн хандив тусламжийн хэмжээг Төсвийн тухай

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

			Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад компанитай хамтран ажиллах	байгууллагын батлагдсан төсвийн 50 хувиас хэтрэхгүй байна”.			хуулийн 25.3-т заасан хэмжээгээр тогтоон ажиллана.
6	Уурхайн хэрэгцээт барааг орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ, эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хангах чиглэлээр хамтран ажиллана	Мах, сүүний хэрэгцээг-1.5 тн мах, 100 литр сүү Хүнсний ногооны хэрэгцээ-1.8 тн төмс, 0.3 тн хүнсний ногоо, Ажлын хувцасны хэрэгцээ-Ажлын бээлий		-	29.5		
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>						<b>44.400.0 сая.төг</b>	

**ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
<b>Байгалийн аюул гамшиг</b>							
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл	Байгалийн аюул гамшигийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж		1	100.0	500.0	2024-2028 он	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-/сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17/
<b>Галын аюул</b>							
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Галын аюул эрсдэл	-	-	3000.0	2024-2028 он	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
	Уурхайн болзошгүй үерээс хамгаалах байгууламж (суваг, шуудуу, далан хаалт) барих (www.achhold-ing.mn)		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2024-2028 он			
<b>Хөдөлмөр аюулгүй ажиллагааны талаар</b>							



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	2024-2028 он	MNS 4968:200“ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж”
	Ослын үед ажиллах ИТА, ажилчдын үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, сургалт явуулах				
	Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх				
	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах				
<b>Нийт зардал мян.төг</b>			<b>3500.000 сая.төг</b>		

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Мөнгөн нуруу” ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 3R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг 9.500.000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд доорх арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 8.1.9.б-д заасны дагуу энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэхээр бүртгүүлж сумын Засаг даргатай гэрээ байгуулан зөвшөөрөл авах;
- Үйлдвэрийн түүхий эд болох хог хаягдлыг өөрсдөө тээвэрлэх тохиолдолд хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож, сумын Засаг даргаар батлуулж мөрдөнө
- Сэргээн ашигласан, дахин боловсруулсан, устгасан, булшилсан хог хаягдлын бүртгэл хөтөлж мэдээллийн сан бүрдүүлнэ
- Хог хаягдлыг багасгах, хянах дотоод журам боловсруулах
- Хогийг анхан шатанд нь ангилан, ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлын хувь хэмжээг нэмэгдүүлж ажиллах.
- Уурхайн оффис, засварын цехийн гадна болон дотор талбайд ангилан ялгалттай хогийн сав байршуулж, битүүмжлэл сайтай байлгах. Хогийн сав нь доорх шаардлагыг хангана.
- ✓ Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн
- ✓ Галд тэсвэртэй материалаар хийгдсэн
- ✓ Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн битүүмжлэлтэй
- Орон нутагт жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор хог хаягдлыг тээвэрлэх, устгах зэрэг ажлуудыг гүйцэтгэх эрх бүхий орон нутгийн компани, сумын удирдлагатай хамтарсан гэрээ байгуулан хог хаягдлыг тогтмол хугацаанд тээвэрлүүлж байх.
- Сумын Засаг даргаас тогтоож өгсөн, өөрийн байгууллагын хариуцсан 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал цас мөсийг цэвэрлэх
- Уурхайн үйл ажиллагаанаас аюултай хог хаягдал гарсан тохиолдолд /шатахуун, шатах тослох материал, химийн бодисын сав, баглаа боодол, аккумулятор, дугуй, хаягдал г.м/- Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 23 дугаар зүйлд заасан хугацаанд аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалан, түүнийг устгах, дахин ашиглах тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан ажиллах. Монгол улсын хэмжээнд хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 23 аж ахуй нэгж байдгаас гялгар уут, хуванцар, дугуй боловсруулах -7, аккумулятор боловсруулах -3, хаягдал тос боловсруулах -2 байгууллагууд байдаг байна.
- Аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлж, зарим хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалах тохиолдолд тусгай зөвшөөрөл авч, түр хадгалахдаа Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 33-р зүйлд заасан шаардлагыг баримтална.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Энгийн хог хаягдал	Хогийн сав нь хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тундасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хогийн савыг уурхайн хотхонд байрлуулах	Уурхайн хотхон, ШТС, засварын төв	ш	2000.0	2000.0*2 удаа=4000.0	4000.0	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	<ul style="list-style-type: none"> <li>- Хог хаягдлын тухай хууль</li> <li>- Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах журам</li> <li>- Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам MNS5344:2011.</li> <li>- Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага</li> </ul>
	Хог хаягдал хадгалах сав, түүний орчимд ариутгал, цэвэрлэгээ хийх	Хог хаягдал хадгалах түр цэг	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах			7 хоногт нэг удаа	
	Хог хаягдлыг ангилан ялгаж, Орхонтуул сумын ТҮК-тай гэрээ байгуулж, тээвэрлэх	Уурхайн бүсээс	удаа	Сард 50.0	Жилд 600	600.0*5жил=3000.0	Гэрээнд заасан хугацаанд	
	Төслийн талбай орчмын эргэн тойронд 50м зайд цэвэрлэгээ хийх	Уурхайн бүсэд	удаа		Сард нэг удаа		Сард нэг удаа	
<b>Аюултай хог хаягдал</b>	Шингэн хаягдал хаях цооног /септиктанк/ дахь бохирдлын хэмжээг 70-80% дүүргэлттэй үед соруулах	Уурхайн хотхон	удаа	Гүйцэтгэлээр	1	Үйл ажиллагааны зардалд тусгах	Үйл ажиллагааны туршид	
	Төслийн үйл ажиллагаанаас гарч буй аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, журмын дагуу түр хадгалан, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх	Уурхайн хотхон	Уурхайн талбай	Гүйцэтгэлээр	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол гэрээнд заасан хугацаанд	
	Аюултай хог хаягдлыг тусгайлсан талбай бэлдэж тэмдэг тэмдэглэгээ хийж түр хадгалах	Үйлдвэрийн талбай	удаа					

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Үүссэн аюултай хог хаягдлыг хог хаягдал цуглуулах тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх	ШТС, засварын төв	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах	Гэрээнд заасан хугацаанд	
	Уурхайн хаалтын үед барилга нураалтаас үүссэн хог хаягдлыг ангилан ялгаж дахин боловсруулах боломжтойг тухайн цэгт өгөх, бусад хаягдлыг нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх	Уурхайн бүсэд	-	Үйл ажиллагааны зардалд тусгах бөгөөд 2.5 сая төгрөгөөр тооцов	Уурхайн хаалтын үе шатанд	
<b>НИЙТ ЗАРДАЛ МЯН.ТӨГ</b>					<b>9.500.000 сая.төг</b>	

### **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР (ОХШХ)**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.1-р зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар “Мөнгөн нуруу” ХХК нь Дэнжийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн үед тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловруулан хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсан байна.

Хуулийн дээрх заалтыг удирдлага болгон төслийг хэрэгжүүлэх явцад “Мөнгөн нуруу” ХХК-аас байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчин ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д заасны дагуу байгалийн бүрдэл тус бүрээр энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг (ОХШХ) боловсруулав.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ “ДЭНЖ АЛТНЫ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал мян.төг	Баримтлах стандарт, арга аргачлал
<b>Агаарын чанар</b>						
CO <sub>2</sub> , NO <sub>2</sub> SO <sub>2</sub> (PM10 PM 2.5)	Төслийн талбай орчимд 4 цэг	Жилд 3 удаа	4 цэгт 3 удаа	60.0төг*4 цэг*4 удаа*5жил	4 800.0	-MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага - MNS 5002:2000
Дуу шуугианы хэмжээ				26.0төг*3 удаа*5жил	390.0	
<b>Хөрс</b>						
Хөрсний агрохимийн үзүүлэлт	Төслийн талбайн эрүүл газрын хөрснөөс 3-цэг	Жилд 2 удаа	3 цэгт 7 дээж	Нийт 3 цэгт*7 дээж*2 удаа /26.0/*5 жил	1 820.0	- (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарт - MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ.
Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Хог хаягдлын цэг-1	Жилд 2 удаа дулааны улиралд	2 цэгт 2 удаа	25.0төг*2удаа*5 жил	250.0	
Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)	Төслийн талбайн ил гарсан хөрснөөс 2-цэг	Жилд 2 удаа	2 цэгт 2 удаа	Нийт 2 цэгт*2 дээж*2 удаа /26.0/*5 жил	520.0	
<b>Усны чанар</b>						
Ерөнхий хими бактерлоги	Унд ахуйн ус 1 цэг	Жилд 2 удаа	2 цэгт 2 удаа	75.0төг*2удаа*5жил	750.0	-MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
<b>НИЙТ ЗАРДАЛ МЯН.ТӨГ 5 ЖИЛЭЭР</b>					<b>8 530.000 сая.төг</b>	



**БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

Төсөл хэрэгжүүлэгч “Мөнгөн нуруу” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайланг хүргүүлэх ба төсөл хэрэгжих аймгийн байгаль орчны газар, сумын Засаг даргын тамгын газарт тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ.

**БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ**

БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион бйгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирнааны төв байгууллага	Тайлан хүргүүлж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүрийн 11 сард	-	Байгаль орчны мэргэжилтэн	БОАЖЯ
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	-	Байгаль орчны мэргэжилтэн Үйл ажиллагааны менежер	Засаг даргын тамгын газарт
Байгаль орчны хяналтын улсын байцгагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	тайлагнах	Үйл ажиллагааны явцад түүх дурсгалт зүйл болон соёлын олдвор олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар	Тухай бүрд	-		
Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд	тайлагнах	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй гомдлыг байрагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх		-		Иргэдэд